

# Итгэлээр үйлдэх гэдэг нь ямар утгатай вэ?

ШИНЭ ГЭРЭЭНИЙ СЕМИНАРЫН МАТЕРИАЛ

Та *Төгс эзэмших сургаалыг судлах үндсэн материал* (2022) дахь “Сүнслэг мэдлэг олж авах нь,” 1–2, 5–7-р догол мөрийг мөн Арван хоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Нийл Л.Андэрсэны дараах үгийг уншаарай. Суралцах явцдаа та итгэлээр үйлдэх гэж ямар утгатай үг болохыг мөн асуултууд тулгарсан үед энэ зарчмыг мөрдөхөд юу тус болохыг олж мэд.



Итгэл тохиолдлоор бидэн дээр ирдэггүй бөгөөд гарал үүслээс шалтгаалан бидэнтэй хамт байдаггүй. ... Есүс Христэд итгэх итгэл нь биднийг зөв зохистой байж, үүнийг эрэлхийлж, хамгаалах үед тэнгэрээс ирдэг бэлэг юм. ... Та нар ирээдүйд хэр их итгэлтэй байх нь санамсаргүй байдлаас бус, харин сонголтоос шалтгаалдаг. ...

Итгэл хэзээ ч асуулт бүрийн хариултыг шаарддаггүй бөгөөд заримдаа “би бүх зүйлийг мэдэхгүй ч гэсэн дагалдагчийн амьдралаар амьдрахад хангалттай зүйлийг мэднэ” гэсэн хандлагатайгаар урагш тэмүүлэх баталгаа, урам зоригийг эрэлхийлж байдаг.

Байнга итгэлдээ эргэлзэж, итгэлгүй мөн итгэл багатай хүмүүсийн үгийг сонсох нь Есүс Христэд болон Сэргээлтэд итгэх итгэлийг сулруулдаг. “Харин төрөлх хүн Бурханы Сүнсний зүйлсийг хүлээж авдаггүй. Учир нь тийм хүнд эдгээр нь мунхаг явдал” [1 Коринт 2:14]. ...

Та нарын итгэл бага байж болох ч зөв шударга сонголтууд Бурханд итгэх итгэл найдварыг авчирснаар итгэл тань өсдөг. (Нийл Л.Андэрсэн, “Итгэлийг тохиолдлоор бус, сонголтоор олж авдаг,” *Ensign*, Nov. 2015, 65–67 эсвэл *2015 оны 10-р сарын Ерөнхий чуулган*, 54–56)

- Бидэнд асуулт, асуудал тулгарах үед итгэлээр үйлдэх нь яагаад чухал гэж та бодож байна вэ?
- Итгэлээр үйлдэх гэдэг нь юу гэсэн утгатай үг болох талаар эдгээр унших материалаас та юу сурч мэдсэн бэ?